

Эрүүл мэндийн яамны 80 жилийн ойд

Томуугийн дэгдэлтийн эсрэг 1944 онд авч байсан арга хэмжээний тухай баримт

Тэр үеийн эрүүл мэндийн албад 1944 онд томуу өвчинтэй тэмцэх арга хэмжээг зохин байгуулж байсан тухай шуурхай зөвлөлгөөний протокол (Зураг 1) Үндэсний төв архивд хадгалагдаж байна. Орос хэлээр бичсэн протоколыг орчуулна толуулж байна. Ариун цэвэр халдваргүйжүүлэлтийн хэлтсийн байцаагч Банишевская, хотын халдвар судлалын эмч Попова, ДХЯ-ны Эмнэлгийн ерөнхий эмч Ушакова нарын оролцсон 1944 оны 1 сарын 10-нд болсон томуу өвчинтэй тэмцэх бодит арга хэмжээний талаар Улсын төв эмнэлгийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн хийсэн нь

Байлцсан: Анфилогов, Агажанова, Кушниская, Липовецкая, Добромьельский, Гринберг, Рошина, Хлебникова, Банишевский, Чой-Сурун, Попова

Доктор Анфилогов: Халдварын хэмжээ үлэмж их байна. Төв эмнэлгийн эрхлэгч өнөөдөр дахин ханиадны 200 шинэ тохиолдол бүртгэж байна. Бид нэн даруй авч хэрэгжүүлэх арга хэмжээнийхээ саналуудаа хэлэх ёстой. Өвчлөлийн хэлбэр нь “хүнд” явцтай байна. Бид дараах асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна. Үүнд:

1. Өвчтөнийг хүлээж авах,
2. Хаана хэвтүүлэх,
3. Хэнд хүлээлгэж өгөх,
4. Бусад тасгуудын хэвтэж байгаа өвчтнүүдийг анхаарах? Өвчтөнийг үзэх - Ерөнхий үзлэг эмчилгээ хийх.

Төрөх тасагт онцгой шаардлагатай байна. Амбулаторийн үзлэгт дотрын эмч Прыткова-г нэмж хувиарля. Хэрвээ маргааш өвчтөнүүд нэмэгдвэл дахин эмч нэмж өгье. Тасгуудад ханиадтай өвчтөнүүдийг илрүүлж тусгаарлана. Миний бодлоор ханиадтай өвчтөнүүдийг одоогоор хэвтүүлэх хэрэггүй гэж бодож байна. Тасгийн ажилтнуудыг бүгдийг үзлэгт хамруулах. Мэс заслын тасгийн ажилтнууд бүгд маск заавал зүүх ёстой. Бие бүрэлдэхүүн болон өвчтөнүүдтэй ярилцлага хийх ёстой. Эргэлт оруулахыг зогсоож, тусгай ажилтнаар эргэлтийг дамжуулах. Энэ бол өвчтөнүүдтэй холбогдуулан авах арга хэмжээ болно.

Их эмч Кушниская: Хэрвээ салстын өөрчлөлттэй, халуурч байвал өвчтөнийг тусгаарлана. Дотрын тасагт эргэлт их ирж байна ийм учраас хаалганд нь яаралтай жижиг цонх хийх хэрэгтэй байна. Дотрын тасагт томуутай өвчтөн их байна. Тасгийг хлораминээр ариутгах.

Их эмч Агажанова: Гэрээр тусламж үзүүлэх тусламжийн машингүй байна. Үүнийг нэн даруй залруулах хэрэгтэй байна. Амбулаторид дотрын эмчийг 7 цагаар гаргаж өгөх хэрэгтэй байна. Эмчилгээнд: кальцекс ба салицилатыг хэрэглэе

Их эмч Липовецкая: Эмнэлгийг бүхэлд нь хорманаар хангах. Кварцын гэрэл бол маш сайн хэрэгсэл мөн. Тасагт гаднын хүн оруулахгүй байх. Халдварын тасагт тусгай палат гаргах

Их эмч Баженов: Эмнэлгийн ажилчид олноороо томуугаар өвчилвөл яах вэ?

Анфилогов: Үлдсэн бүх арга хэмжээгээ дээд хэмжээгээр ашиглана.

Их эмч Банишевская: Хотод 1180 хүн өвдсөн гэдэг тоо бүрэн бишээ. Томуу хүнд хэлбэрээр үргэлжилж байна. Испанийн цартахлыг санагдуулж байна. Ханиад 12 сараас зүүн аймгуудаас гарч эхэлсэн. Хүн нас барсан тохиолдол ганц нэг байна. Өвчтөнүүдийг хэвтүүлэх шаардлагагүй. Орон гэрт нь тусгаараж хэвтүүлээд, хүч нэмэгдүүлсэн арга хэмжээ авч, нийтэд энэ талаар мэдээлэх хэрэгтэй байна. Шал болон бусад зүйлүүдийг хлорын 5%-ийн уусмалаар арчиж, цэвэрлэ. Одоогоор эмнэлэг гэгээрлийн ажлыг өргөн хэмжээгээр явуулах хэрэгтэй. Хүндэрсэн тохиолдолд хэвтэж эмчлүүлэхгүй бол болохгүй. Хэрвээ эмнэлэг тусгай байр гаргаж чадахгүй бол энэ асуудлыг бид ЭМЯ-нд тавья. Ханиадаар өвчилж байгаа өвчтөнүүдийн мэдээллийг өдөр тутам гаргаж өгч бай.

Практик саналууд:

1.1944 оны 1 сарын 10-ны байдлаар ханиадны тоо мэдээлэл албан бус тоогоор 1180 хүн гэж дүгнэж болно. Дээрхи байдлаас дүгнэж Улаанбаатар хотод томуугийн дэгдэлт болж байна гэж үзлээ.

2.Одоогийн байдлаар түлшний дутагдлаас болж даарч, хөрч байгаа нь өвчин тархах гол хүчин зүйл болж байна.

3.Ханиадаар өвчлөгсдийг бүгдийг нь гэрт нь тусгаарлаж чадахгүй байгаа нь халдварыг маш амархан тарааж байна. Гэрт нь үзүүлэх тусламж дутагдалтай байна. Гэрээр тусламж үзүүлэх эмч нар болон машин дутагдалтай байна.

4.Халдвар тархахаас урьдчилан сэргийлж, дараах арга хэмжээг авья.

а. Эмнэлгийн байгууллагууд,

Сургууль,

Цэцэрлэг,

Үйлдвэр аж ахуй,